- Байгууллагын стратегийн зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны хэрэгцээг хангахад цаг үеийн эрэлт шаардлагад нийцсэн мэдлэг чадварыг эзэмшүүлэх, сургаж хөгжүүлэх, мэргэшүүлэх

Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээнд орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын статустай байна. Өмчийн 100 хувийг төр, үүнээс 100 хувь орон нутгийн өмч байна.

### **3.2 ОНӨААТҮГ-ын гадаад, дотоод орчин**

“Баян-Өлгий Цахилгаан шугам сүлжээний газар” ОНӨААТҮГ нь анх Баян-Өлгий аймгийн төвд 1951 онд “ДТ-54” маягийн дизель станц суурилуулснаар эрчим хүчний үйлдвэрийн суурь тавигдсан байна. Улмаар 1952-1965 онуудад дизель станцаар, 1965-1982 онуудад Чехославак улсын техник, эдийн засгийн тусламжаар баригдсан 3 мВт-ын хүчин чадалтай Дизелийн цахилгаан станцаар хэрэглэгчдийг цахилгаанаар хангаж байсан байна. Баян-Өлгий аймаг 1997 онд Баруун бүсийн нэгдсэн сүлжээнд холбогдсоноор аймаг, сумуудын цахилгаан хэрэглэгчид байнгын эрчим хүчтэй болсон байна.

Монгол Улсын Дэд бүтцийн сайдын 1999 оны шийдвэрээр “Эрчим” ХК-ийн бүтцийг өөрчилж цахилгаан түгээх, цахилгаанаар хангах үүрэг бүхий Цахилгаан шугам сүлжээний газар нэртэйгээр байгуулсан байна.

Монгол Улсын Их Хурлын 1997 оны 5 дугаар сарын 13-ны өдрийн 29 дүгээр тогтоолоор Баян-Өлгий аймгийн Цахилгаан шугам сүлжээний газрыг төрийн өмчөөс орон нутгийн өмчлөлд шилжүүлэн, орон нутгийн өмчит үйлдвэрийн газар болсон байна.

Компанийн тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.5-д “Төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газрыг компанийн хэлбэрт оруулан өөрчлөн зохион байгуулах замаар үүссэн төрийн болон орон нутгийн өмчит компанийн үйл ажиллагааг энэ хуулиар зохицуулна” гэж заажээ.

Компанийн удирдлага болон ТУЗ-ийн бүрэлдэхүүнийг аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн тогтоолоор томилж байгаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн холбогдох заалттай нийцэж байна. Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2020 оны 101 дүгээр тогтоолоор ТУЗ-ийн бүрэлдэхүүнийг 5 гишүүнтэйгээр шинэчлэн тогтоосон байна.

“Баян-Өлгий Цахилгаан шугам сүлжээний газар” ОНӨААТҮГ-ын Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн цалин, урамшууллыг 21.0 сая төгрөгөөр тогтоосон нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 12 дахь заалт, Засгийн газрын 2016 оны 80 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх журам”-ын 3.7-д “...цалин хөлсний хэмжээг тухайн хуулийн этгээдийн үйл ажиллагааны хүрээ, санхүү, эдийн засгийн байдлыг харгалзан Хувьцаа эзэмшигчдийн хурал тогтооно. Цалин хөлсний хэмжээ нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2 дахин нэмэгдүүлснээс ихгүй байна” гэсэн заалттай нийцэж байна.

Монгол Улсын Засгийн газрын “2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 4.4.10-т “Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, ашиглалт, хамгаалалтыг сайжруулж, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн засаглалыг олон улсын жишигт нийцүүлэх, газрын хууль тогтоомжийг төрийн байгууламж нэгдмэл байх

зарчим болон өмчийн эрх зүйд нийцүүлэн боловсронгуй болгоно” гэж заасан. Энэ хүрээнд хийгдсэн арга хэмжээ байхгүй байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороогүй байна.

Эрчим хүчний зохицуулах хорооны 2024 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн 711 тоот тогтоолоор цахилгаан эрчим хүчний нэгдсэн сүлжээнд холбогдсон хэрэглэгчдэд борлуулах цахилгааны тарифыг индексжүүлж, борлуулах зарим цахилгааны чадлын тарифыг өөрчилсөн байна.

Аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанаас тус байгууллагын 2022, 2023, 2024 оны санхүүгийн үйл ажиллагаанд 2025 оны 2, 3 дугаар сард шалгалт хийсэн байна.

Тус газрын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна

Дотоод аудиторын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудиторын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

ЦШСГ-ын 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

“Баян-Өлгий Цахилгаан шугам сүлжээний газар” ОНӨААТҮГ-ын “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг “Тунгалаг бүртгэл аудит” ХХК-аар 2020 онд хийлгэж, мөрдөж ажиллаж ирсэн байна.

Тус ОНӨААТҮГ-ын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### **3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад орсон өөрчлөлт**

“Баян-Өлгий Цахилгаан шугам сүлжээний газар” ОНӨААТҮГ-ын 2024 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалаар баталсан аж ахуйн нэгжид мөрдөгдөх “Санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд ОНӨААТҮГ-ын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 1,312.9 сая төгрөгөөр буюу 11.54 хувиар өссөн байна.

## Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт                                     | Эхний<br>үлдэгдэл    | Эцсийн<br>үлдэгдэл   | Өөрчлөлт            |
|--|----------------------|----------------------|---------------------|
| Б  | 1                    | 2                    | 3=2-1               |
| Мөнгөн хөрөнгө                               | 1,733,325.74         | 1,629,841.46         | -103,484.28         |
| Авлага                                       | 1,782,366.33         | 2,444,740.85         | 662,374.51          |
| Бараа материал                               | 445,159.40           | 1,033,424.73         | 588,265.33          |
| Үндсэн хөрөнгө                               | 7,412,150.68         | 7,577,960.61         | 165,809.94          |
| <b>Нийт хөрөнгө</b>                          | <b>11,373,002.14</b> | <b>12,685,967.64</b> | <b>1,312,965.50</b> |
| Богино хугацаат өр төлбөр                    | 878,562.97           | 1,391,776.61         | 513,213.65          |
| Урт хугацаат өр төлбөр                       | 2,136,587.74         | 2,136,587.74         | 0.00                |
| Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/     | 8,357,851.44         | 9,157,603.29         | 799,751.85          |
| <b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b> | <b>11,373,002.14</b> | <b>12,685,967.64</b> | <b>1,312,965.50</b> |

Мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, өр төлбөр, засгийн газрын хувь оролцоо данснуудад өмнөх оны үзүүлэлтээс нөлөө бүхий өөрчлөлт гарсан байна.

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 1,629.8 сая төгрөг болж 103.5 сая төгрөгөөр буурсан нь арилжааны банкны мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй холбоотой байна. Үүнд ХААН банканд 125.9 сая төгрөгийн, Голомт банканд 1,100.6 сая төгрөгийн, Төрийн банканд 362.1 сая төгрөгийн, Хас банканд 34.7 сая төгрөгийн Капитрон банканд 6.5 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна. Касст 7.9 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Авлагын дансны үлдэгдэл 2,444.7 сая төгрөг болж 662.4 сая төгрөгөөр өссөн байна. Үүнээс. айл өрхөөс авах цахилгааны авлага 938.2 сая төгрөг, байгууллагаас авах цахилгааны авлага 1,186.1 сая төгрөг, аймгийн Татварын хэлтсээс авах авлага 37.7 сая төгрөг, компани хоорондын авлага 64.5 сая төгрөг, иргэн болон байгууллагаас авах дансны авлага 192.2 сая төгрөг, найдваргүй авлага 26.0 сая төгрөг байна.

Дансны авлагын насжилтыг судалгаагаар авч үзвэл дараах байдалтай байна.

| № | Авлагын насжилт           | Хувь хүн          | Аж ахуйн нэгж       | Нийт дүн            |
|---|---------------------------|-------------------|---------------------|---------------------|
| 1 | Хугацаанд төлөгдөх авлага | 957,577.57        | 1,433,163.88        | 2,390,741.45        |
| 2 | 2-3 жил хүртлэх авлага    | -                 | 27,992.66           | 27,992.66           |
| 3 | 3 дээш жилийн авлага      | -                 | -                   | -                   |
| 4 | Найдваргүй авлага         | 26,006.73         | -                   | 26,006.73           |
|   | <b>Бүгд дүн</b>           | <b>983,584.30</b> | <b>1,461,156.54</b> | <b>2,444,740.85</b> |

Авлагын үлдэгдлийг насжилтын судалгаагаар авч үзвэл нийт авлагын 97.7 хувь буюу 2,390.7 сая төгрөг нь төлөгдөх хугацаандаа байгаа авлага, 36 сараас дээш хугацаатай хугацаа хэтэрсэн аж ахуйн нэгжийн авлага 28.0 сая төгрөг, хувь хүмүүстэй холбоотой төлөгдөх боломжгүй буюу найдваргүй болсон 2.6 сая төгрөгийн авлага байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 1,033.4 сая төгрөг болж 588.3 сая төгрөгөөр өссөн нь тайлант онд 1,635.2 сая төгрөгийн бараа материалыг худалдан авч, 10.4 сая төгрөгийн бараа материалыг үнэгүй хүлээн авч үйл ажиллагаанд 1,057.4 сая төгрөгийн бараа материалыг зарцуулсантай холбоотой байна.

Бараа материалын дансны үлдэгдэлд ашиглалтгүй бараа материал байхгүй байна. Оны эцэст их хэмжээний худалдан авалт хийж бараа материалын нөөц үүсгээгүй байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл өмнөх оны үлдэгдлээс 165.8 сая төгрөгөөр өссөн байна. Байгууллагын хөрөнгөөр 737.5 сая төгрөгөөр үндсэн хөрөнгө худалдан авч, төсвийн хөрөнгө оруулалтаар 520.4 сая төгрөгийн тоног төхөөрөмжийг үнэгүй хүлээн авч, үндсэн хөрөнгөд 1,092.2 сая төгрөгийн элэгдэл байгуулсан байна.

Богино хугацаат өр төлбөр дансны үлдэгдэл 1,391.8 сая төгрөг болж 513.2 сая төгрөгөөр өссөн нь “Алтай таван богд” төслийн 746.3 сая төгрөгийн, “Сыргалы” төслийн 541.2 сая төгрөгийн санхүүжилт жилийн эцэст оройтож ирсэнтэй холбоотой байна.

Богино хугацаат өр төлбөрийг насжилтын судалгаагаар авч үзвэл дараах байдалтай байна.

#### Мянган төг

| № | Өглөгийн насжилт            | Хувь хүн | Аж ахуйн нэгж | Нийт дүн     |
|---|-----------------------------|----------|---------------|--------------|
| 1 | Хугацаанд нь төлөгдөх өглөг | 1,593.50 | 1,383,685.13  | 1,385,278.63 |
| 2 | 2-3 жил хүртлэх өглөг       | -        | 6,497.99      | 6,497.99     |
| 3 | 3 дээш жилийн өглөг         | -        | -             | -            |
| 4 | Төлөгдөх боломжгүй өглөг    | -        | -             | -            |
|   | <b>Бүгд дүн</b>             | 1,593.50 | 1,390,183.11  | 1,391,776.61 |

Урт хугацаат өр төлбөр дансны үлдэгдэлд өөрчлөлт ороогүй байна. ЦШСГ нь 2,136.6 сая төгрөгийн төслийн нь урт хугацаат өр төлбөртэй бөгөөд ямар нэгэн төлөлт хийгдээгүй, хугацаа хэтэрсэн байна.

Санхүүгийн тайланд зардал өртгийн талаарх мэдээллийг бэлтгэх зорилгын дагуу борлуулсан бүтээгдэхүүний өртөг, ерөнхий ба удирдлагын зардал, хөрөнгө оруулалтын их засвар, элэгдлийн зардал, орлогын албан татвараас бусад татвар, үйл ажиллагааны зардал гэж ангилсан байна. Өмнөх онтой харьцуулахад нийт зардал 34.5 сая төгрөгөөр буурсан нь бусад зардлууд буурсантай холбоотой байна. Тайлант онд 142.7 сая төгрөгийн ашигтай ажилласан байна.

### 3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу “Баян-Өлгий Цахилгаан шугам сүлжээний газар” ОНӨААТҮГ санхүүгийн төлөвлөгөө /техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөөг боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2.3-т “Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдтэй эцэслэн тохирсон зорилтын саналыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад жил бүрийн 04 дүгээр сарын 05-ны дотор хүргүүлнэ”,

21.10-т “Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд аудитын дүгнэлт гарснаас хойш долоо хоногийн дотор тайлангаа аудитын дүгнэлтийн хамт төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ” гэж заасан байна.

Цахилгаан шугам сүлжээний газар нь хуулийн дээрх заалтын дагуу үйлдвэрийн газрын хүрэх зорилт, түүнийг хэрэгжүүлэх саналыг Эрчим хүчний зохицуулах хороонд хүргүүлж, хянуулж, батлуулж ажилласан байна.

Тайлант оны нийт орлогыг 16,831.9 сая төгрөгөөр, нийт зардлыг 16,831.9 сая төгрөгөөр, ашиг алдагдалгүй ажиллахаар төлөвлөсөн байна.

Гүйцэтгэлээр 17,830.7 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 17,687.9 сая төгрөгийн зардал гарган, 142.7 сая төгрөгийн татварын өмнөх ашигтай ажилласан байна.

Эрчим хүчний зохицуулах хорооны 2024 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн 711 тоот тогтоолоор цахилгаан эрчим хүчний нэгдсэн сүлжээнд холбогдсон хэрэглэгчдэд борлуулах цахилгааны тарифыг индексжүүлж, борлуулах зарим цахилгааны чадлын тарифыг шинэчлэн тогтоосонтой холбоотой борлуулалтын орлого өссөн байна.

Нийт зардлын гүйцэтгэл 17,687.9 сая төгрөг болж, төлөвлөснөөс 856.0 сая төгрөг буюу 5 хувиар илүү гүйцэтгэлтэй гарсан байна.

Тайлант онд ашиг алдагдалгүй ажиллахаар төлөвлөснөөс 142.7 сая төгрөгөөр давж биелэгдсэн нь нийт орлого нь өмнөх оноос 3,143.1 сая төгрөгөөр өссөн нь нөлөөлжээ.

## **4. АУДИТЫН ТАЙЛАН**

---

### **4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Цахилгаан шугам сүлжээний газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторовын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Ж.Назгүл гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Х.Женисбек, дарга, тэргүүлэх аудитор Ж.Айгүл нар тус тус хэрэгжүүлсэн.

“Баян-Өлгий Цахилгаан шугам сүлжээ” орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын 2024 оны санхүүгийн тайланг 2024 оны 3 дугаар сарын 11-ны өдрийн 86 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт хөрөнгийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны нийт зардлын 4,310.4 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 64.6 сая төгрөгөөр, тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоосон.

Гүйцэтгэлийн материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж 2024 оны нийт зардлын 5,164.6 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 77.4 сая төгрөгөөр шинэчлэн тогтоосон. Тайлант оны нийт зардлын хэмжээ өмнөх оноос 854.2 сая төгрөгөөр өссөн тул материаллаг байдлыг шинэчлэн тогтоосон болно.

#### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтэд Үндэсний аудитын газрын нэгдсэн удирдамжаар нийцлийн аудит хийгдэх болсон тул энэхүү аудитад хамруулаагүй болно.

#### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

##### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны мэдээллээс санхүүгийн тайлангийн аудитын программд орсон мэдээллийн хэрэгжилтийг шалгасан.

Шилэн дансанд цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын нийтдээ 9,134.4 сая төгрөгийн 575 мөнгөн гүйлгээ, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 14,824.0 сая төгрөгийн 306 мөнгөн гүйлгээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах шийдвэрийн гүйлгээг бүрэн мэдээлсэн байна. Шилэн дансанд мэдээлсэн байдлын хэрэгжилтийн хувь 100 хувьтай байна.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хийсэн аудитаар алдаа, зөрчил илрээгүй тул нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

##### **4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Бусад хууль тогтоомжийн хүрээнд асуудал гараагүй. Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн хүрээнд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

#### **4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

##### **4.5.1 Завсрын аудитын талаар**

Цахилгаан шугам сүлжээний газрын 2024 оны санхүүгийн тайланд завсрын аудит хийгдээгүй.

##### **4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар нийт 192.1 сая төгрөгийн зөрчил илэрснээс, 8.7 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 183.3 сая төгрөгийн зөрчлийг арилгах 3 зөвлөмж өгсөн. Аудитын шийдвэрийн хэрэгжилтийг давтан шалгаж үзэхэд аудитаар өгсөн 1 зөвлөмжийн хэрэгжилтийг тайлагнаагүй, биелэлт нь хангалтгүй тул давтан шалгалтаар албан шаардлага хүргүүлэв.

Хүснэгт 2. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт  
/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт        | Өмнөх аудитаар өгсөн |                  | Биелэлт  |                  |             |
|-----------------|----------------------|------------------|----------|------------------|-------------|
|                 | Тоо                  | Дүн              | Тоо      | Дүн              | Хувь        |
| Акт             | 1                    | 8,787.7          | 1        | 8,787.7          | 100         |
| Албан шаардлага |                      |                  |          |                  |             |
| Зөвлөмж         | 3                    | 183,301.8        | 2        | 183,301.8        | 66.6        |
| <b>Нийт дүн</b> | <b>4</b>             | <b>192,089.5</b> | <b>3</b> | <b>192,089.5</b> | <b>83.3</b> |

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Санхүүгийн тайлангийн аудитаар Цахилгаан шугам сүлжээний газрын 2024 оны санхүүгийн тайланд эрсдэлтэй гэж сонгосон ажил гүйлгээ, дансуудад түүврийн аргаар горим сорил хэрэгжүүлсэн бөгөөд цаг хугацааны хязгаарлагдмал байдлаас шалтгаалж бүх ажил гүйлгээ, дансыг шалгах боломжгүй тул гүйцэтгэлийн шалгалтаар худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилт, үйл ажиллагааны зардлын зарцуулалтыг дэлгэрэнгүй шалгах шаардлагатай болно.

#### 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар санхүүгийн тайланд залруулга хийгдээгүй болно. Аудитаар нийт 1,088.3 сая төгрөгийн зөрчил илэрч 1,088.3 сая төгрөгийн албан шаардлага өгсөн.

##### 5.1 Төлбөрийн акт

Төлбөрийн акт тогтоогдоогүй.

##### 5.2 Албан шаардлага

1. Аудитын дүнгээр 1,088.3 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага өгөв. Үүнд:

1. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй, оны эцэст 14 аж ахуйн нэгжтэй холбоотой 996.6 сая төгрөгийн авлагын, 23 аж ахуйн нэгжтэй холбоотой 91.6 сая төгрөгийн өглөгийн үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, 20.2.6-д “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэсэн заалтыг зөрчиж байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчил арилгуулах албан шаардлага өгөв.

2. Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасныг зөрчиж ЦШСГ-ын 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг 3 дугаар сарын 11-ний өдөр 86 дугаар албан бичгээр ирүүлсэн.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д “Төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээд жилийн

эцсийн санхүүгийн тайлангаа дараа жилийн 02 дугаар сарын 15-ны дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлж, аудит хийсэн тайланг 3 дугаар сарын 15-ны дотор харьяалагдах төсвийн ерөнхийлөн захирагч болон санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх” гэж заасныг зөрчсөн.

Шийдвэрлэсэн нь: Сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлага өгөв.

### 5.3 Зөвлөмж

Зөвлөмж өгөөгүй.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа |     | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан |     | Буруу тусган илэрхийлсэн |     | Үүнээс     |     |              |     | Зөвлөмж |     |
|-------------------|------------|-----|-----------------------------------|-----|--------------------------|-----|------------|-----|--------------|-----|---------|-----|
|                   |            |     |                                   |     |                          |     | Залруулсан |     | Залруулаагүй |     |         |     |
|                   | Тоо        | Дүн | Тоо                               | Дүн | Тоо                      | Дүн | Тоо        | Дүн | Тоо          | Дүн | Тоо     | Дүн |
|                   |            |     |                                   |     |                          |     |            |     |              |     |         |     |
|                   |            |     |                                   |     |                          |     |            |     |              |     |         |     |
| Дүн               |            |     |                                   |     |                          |     |            |     |              |     |         |     |

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга  | Нийт зөрчил |                    | Үүнээс        |     |                 |                    |         |     |                                      |                     |   |     |
|---|-------------|--------------------|---------------|-----|-----------------|--------------------|---------|-----|--------------------------------------|---------------------|---|-----|
|   |             |                    | Төлбөрийн акт |     | Албан шаардлага |                    | Зөвлөмж |     | Хариуцлага тооцуулах албан шаардлага |                     | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал |     |
|   | Тоо         | Дүн                | Тоо           | Дүн | Тоо             | Дүн                | Тоо     | Дүн | Тоо                                  | Албан тушаалтны тоо | Тоо   | Дүн |
| Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг тайлагнаагүй, хэрэгжүүлж ажиллаагүй, авлага өглөгийн үлдэгдлийг тооцоо нийлээгүй | 1           | 1,088,284.1        |               |     | 1               | 1,088,284.1        |         |     |                                      |                     |   |     |
| Санхүүгийн тайлангаа хугацаандаа ирүүлээгүй   | 1           |                    |               |     |                 |                    |         |     | 1                                    | 1                   |   |     |
| <b>Дүн</b>  | <b>2</b>    | <b>1,088,284.1</b> |               |     | <b>2</b>        | <b>1,088,284.1</b> |         |     | <b>1</b>                             | <b>1</b>            |   |     |

